

СОЁМБО МЭДЭЭ

МЭНДЧИЛГЭЭ



БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаа, ЗХУ-ын хошой баатар, БНМАУ-ын баатар, хошууч генерал В.А.Жанибеков, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, сансрын нисэгч М.Ганзориг нар болон тэдний гэр бүл, үр хүүхдүүд, Монгол Улсын нийт иргэд, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Та бүхэнд монгол хүн сансарт ниссэний 40 жилийн түүхт ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье!

Хүн төрөлхтний түүхэнд ХХ зуунд тохиосон олон томоохон үйл явдал, ололт, амжилтын нэг нь сансарт огторгуйг эзэмшсэн явдал билээ. 1981 оны 3 дугаар сарын 22-ны өдөр олон улсын "Интеркосмос" хөтөлбөрийн хүрээнд өнөөгийн Казахстан Улсын нутагт байрлах "Байконур" дахь сансрын буудлаас сансрын нисэгч В.Жанибеков, Ж.Гүррагчаа нарын бүрэлдэхүүнтэй "Союз-39" хөлөг хөөрч, задгай сансарт гаран сансрын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж олон арван шинжлэх ухааны туршилт судалгааг төлөвлөгөөний дагуу явуулан, 3 дугаар сарын 30-ны өдөр эх дэлхийдээ газардсан юм.

Энэхүү үйл явдал нь манай улсын нэрийг дэлхийн сонорт дахин дуурсгасан түүхэн үйл явдал төдийгүй монгол хүн бүрийн омогшил, бахархал, ирээдүйдээ итгэх итгэл, урам зориг, хүсэл тэмүүллийг бадраасан онцгой үйл явдал байсан юм. Сансрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

ажлын хүрээнд сансрын тойрог замд эрдэм шинжилгээ, судалгааны сорилт, туршилт явуулах, тусгай хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх мэдлэг, дадлага, чадвар бүхий өндөр түвшний үндэсний эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн боловсон хүчнүүд хэдэн арваар төрөн гарч, эх орныхоо шинжлэх ухааны салбарыг үсрэнгүй хөгжилд хөтлөн улс орондоо ихийг хийж бүтээсэн явдал нь өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байна.

Тухайн цаг үед манай улс сансарт иргэнээ нисгэсэн дэлхийн 10 дахь, судалгаа шинжилгээний багаж төхөөрөмж бэлтгэж, сансарт туршсан 20 дахь, хөлгийн гадна, задгай сансарт хэмжилт судалгаа хийсэн анхны таван орны нэг болж дэлхий дахины шинжлэх ухааны хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

"Союз-39" хөлөг задгай сансарт "Салют-6" станцтай залгагдаж, тус хөлгийн экипажийн бүрэлдэхүүнтэй хамтран сансрын физик, технологи, байгаль орчны болон анагаах ухаан, биологийн зэрэг 30 орчим туршилтыг амжилттай хэрэгжүүлж, байгаль орчныг зайнаас тандан судлах, түүний үр дүнг геологи, цаг уур, геодези, газар зүйн шинжлэх ухааны салбарт хэрэглэх, сансрын анагаах ухаан, биологийн салбарт судалгаа шинжилгээний ажил явуулах, сансрын холбоо, физик, технологийн ололтыг амьдралд нэвтрүүлэх зэрэг өндөр ач холбогдолтой ажлуудыг зохион байгуулсныг онцлох нь зүйтэй.

Энэ баярт үйл явдлаас хойш хэдийнээ 40 жилийн хугацаа өнгөрсөн болов ч монгол хүн бүр сансрын эрэлхэг хөвгүүдээрээ ямагт бахархаж, Монголын ард түмний ялалт, амжилтын бахдам жишээ, үлгэр дуурайлал нь байсан хэвээр байна.

Эрхэм хүндэт сансрын нисэгчид, энэ үйлсэд өөрсдийн хувь нэмрээ оруулсан бүх эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны салбарын ажилтнууд Та бүхэндээ монгол хүн сансарт ниссэний болон сансрын хамтарсан нислэг үйлдсэн өдрийн мэндийг дахин дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

МОНГОЛ ЦЭРГИЙН СҮР ХҮЧ, СУЛД ХИЙМОРЬ ҮЕИЙН ҮЕД МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР



Эрхэм хүндэт нөхөд өө, Эрхэм хүндэт Зэвсэгт нэгт ахан дүүс ээ, Монгол Улс орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойгоо тэмдэглэж байна.

Нэн түрүүнд Оросын ард түмэн Монголын ард түмнээс үзүүлсэн буцалтгүй тусламж, нөхөрсөг, халуун дулаан сэтгэлд талархаж явдаг билээ.

Оросын ард түмэнд тулгарсан дайны хамгийн хүнд хэцүү үед Монголоос хүнс, нэхий дээл ачсан чингэлтийн цуваа Оросын хотуудад хүрч байсан бөгөөд Өрнөд фронтод Монголоос тусламж болгосон тэмээ хүртэл "үүрэг гүйцэтгэж" байлаа.

Намайг баярлуулсан бас нэг үйл явдал нь ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас уламжлал болгон зохион байгуулдаг Цэргийн наадмын "Танкийн биатлон" төрөлд оролцож байсан Монголын Зэвсэгт хүчний танкийн экипажууд туршлагатай, өндөр хөгжилтэй орнуудын багуудаас түрүүлж, тэр дундаа Оросын танкийн экипажуудыг сандаргаж байсныг харахад бахархал төрж байлаа. Өөрийн улсын багийг биш Монголын багийг илүү дэмжих үе ч байсан. Монголын багууд гайхамшигтай амжилтыг үзүүлсэн билээ.

Өнөөдөр тохиож буй Зөвлөлт-Монголын хамтарсан нислэг үйлдсэний 40 жилийн ойн баярын мэндийг Монголын нийт ард түмэнд дэвшүүлэхийн ялдамд дэлхий дахины нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байгаа энэ цаг үетэй хөл нийлүүлэн хөгжих их амжилтыг Монголын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд хүсэн ерөөе.

Цаашид ч манай хоёр орны цэргийн дээд удирдлага, генерал, офицер, алба хаагчдын нөхөрлөл мөнхөд үргэлжлэх болтугай.

ЗХУ-ЫН ХОШОЙ БААТАР, БНМАУ-ЫН БААТАР, ЧӨЛӨӨНД
БАЙГАА ХОШУУЧ ГЕНЕРАЛ В.А.ЖАНИБЕКОВ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 6°C	☁️ -7°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40°C	☁️ 28°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 8°C	☁️ 4°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,369.0	3,434.0
CNY 🇨🇳	435.40	439.80
RUB 🇷🇺	37.56	39.29
JPY 🇯🇵	25.86	26.49
KRW 🇰🇷	2.46	2.58

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	170
НИЙТ БҮРТГЭГДСЭН	4976
ЭДГЭРСЭН	3447
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	25
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	252
ЭДГЭРСЭН	1000

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.22
/ДАВАА ГАРАГ/

ХАВРЫН ДУНД
ЦАГААГЧИН ТУУЛАЙ
САРЫН НАЙМАН ЦАГААН
ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулвал:
Өвчин өчүүхэн ирнэ

Наран ургах, шингэх:
06.51-19.06

Барилдлага: Рашаан

Шүтэн барилдлага:
Төрөхүй

Суудал: Шороо

Аргын тооллын 3 сарын 22, Сумъяа гараг. Билгийн тооллын9, Хэрцгийн охин одтой, шарагчин могой өдөр. Өдрийн 6 цаг 51 минутад мандан, 19 цаг 06 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТҮҮХЭН ҮЕЧЛЭЛИЙГ ХАРУУЛАХ ЗОХИОМЖИТ БАРИМАЛ ҮЗЭГЧДИЙН ХҮРТЭЭЛ БОЛЛОО



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан ЦДБЭЧ-ын хамт олон Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэн үечлэлийг харуулсан зохиомжит баримлыг бүтээлээ. Тодруулбал, тус баримал нь 8x4 хэмжээтэй бөгөөд Ардын журамт цэргээс Монгол Ардын хувьсгалт цэрэг, Монгол Улсын Зэвсэгт хүчин болон хөгжсөнийг дүрслэн үзүүлснээрээ онцлог юм.

Энэ талаар ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа "Бид бүхэн түүхэн ойн хүрээнд олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж байгаа. Эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх зарим бодит ажлуудын нэг нь Монгол Улсын Зэвсэгт хүчний

түүхэн үечлэлийг харуулсан зохиомжит баримал юм. Тус баримлыг ЦДБЭЧ-ын даргын орлогч, уран сайхны удирдаач, хошууч Л.Баттөр зохиомжилж, ерөнхий найруулагч, Уран бүтээлийн хэлтсийн Тайзны албаны дарга, ахлах ахлагч М.Алтанхуяг, зураач У.Отгонбаатар, цахилгаанчин Ю.Энхбаатар, мужаан С.Баасандорж, жолооч Ц.Ганбаатар, сантехникч С.Бямбадорж нарын алба хаагчид урласан юм. Энэхүү бүтээл нь нэг талаасаа манай орны тусгаар тогтнол, Зэвсэгт хүчний түүхэн замналыг харуулж байгаа хэдий ч нөгөө талаасаа ЦДБЭЧ нь дайнд оролцсон цорын ганц урлагийн байгууллага юм гэдгийг үзэгчдэд таниулах зорилготой" гэв.

"ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ" ҮЗЭСГЭЛЭН ҮҮДЭЭ ДЭЛГЭВ



Ардын журамт цэргийн дайчин эрсээс орчин цагийн арми болон хөгжиж бэхэжсэн Зэвсэгт хүчний түүхэн уламжлал, хөгжил шинэчлэлийг харуулсан "Зэвсэгт хүчин-100 жил" үзэсгэлэнг Монгол цэргийн музейгээс үзэгч олондоо дэглэн толилуулж байна. "Зэвсэгт хүчин-100 жил" үзэсгэлэн нь "Ардын журамт цэргээс Монголын Ардын Арми", "Монголын Зэвсэгт хүчин өнөө үе" гэсэн үндсэн 2 хэсгээс бүрджээ.

1921 оны Ардын журамт цэргээс өнөөгийн Зэвсэгт хүчний дайчид, энхийг сахиулагч нарын түүхэнд холбогдох архивын 100 гаруй баримт, 150 гаруй биет үзмэр, эд өлгийн зүйлсийг дэглэснээс гадна 1200 гаруй гэрэл зураг, баримтат кино орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан үзүүлснээрээ энэ удаагийн үзэсгэлэн онцлог болсон байна.

Тус үзэсгэлэнд Монгол цэргийн музей, Монголын Үндэсний музей, Архивын Ерөнхий газрын Үндэсний төв архив, Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс урьд өмнө үзэгчдийн хүртээл болж байгаагүй ховор түүхэн гэрэл зураг, архивын үнэт баримтууд, Үндэсний музейн сан хөмрөгөөс жанжин Д.Сүхбаатарын дээл, хантааз, отго жинс бүхий малгай, тамганы хайрцаг, Д.Бодоогийн сийлсэн МАН-ын анхны тамга, бийр янтай, өөрийн музейн сан хөмрөгөөс БНМАУ-ыг тунхаглан анхны Үндсэн хууль батлагдсан үеэс гарсан анхны загварын одонгууд, "Баатрын алтан таван хошуу" медаль, үе үеийн цэргийн дүрэмт хувцас, буудлагын зэвсэг зэрэг түүхэн биет үзмэрийг үзэж болох юм.

Мөн мэдрэгчтэй ухаалаг дэлгэц, холограмм төхөөрөмж, ухаалаг зурагт, мэдрэгчтэй яригч, аудио чихэвч, гэрэлт самбар, проектор, VR box, QR код зэргийг ашиглан Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэнд холбогдох гэрэл зураг, архивын баримтуудыг он дарааллын дагуу байршуулж үзэгчид өөрийн сонголтоор түүхэн цаг үеийн баримт материал, гэрэл зурагтай танилцах боломжийг олгож байгаа нь тус үзэсгэлэнгийн гол онцлог, шинэлэг тал болно. Тус үзэсгэлэн энэ сарын 17-ноос 4 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл дэлгэгдэх юм.

Зэвсэгт хүчний 338 дугаар анги

ЦЭРЭГЖЛИЙН БУУДЛАГЫН ТЭМЦЭЭНД 086 ДУГААР ТУСГАЙ РОТ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн нэрэмжит уламжлал болон зохион байгуулагддаг Цэрэгжлийн буудлагын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Энэхүү тэмцээн нь Сүхбаатар аймагт байрлах Төрийн цэргийн байгууллагуудын дунд жил бүр зохиогддог уламжлалтай юм. Тус тэмцээнд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 086 дугаар тусгай ротын ахлах ахлагч Э.Эрдэнэбаатар, Б.Болор-Эрдэнэ нар 78 оноогоор тэргүүн байрт тус тус шалгарлаа.



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

"МИНИЙ МЭДЭХ ЦЭРЭГ" ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ТЭРГҮҮНҮҮД ТОДРОВ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан

тус ангийн харьяа тусгай ротоос "Миний мэдэх цэрэг" сэдэвт гар зургийн уралдааныг

зохион байгууллаа. Тэмцээнд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 65 авьяаслаг сурагч бүтээлээрээ ирүүлснээс бага ангийн төрөлд 15 ангийн сурагч Г.Хулан, Б.Батхүслэн нарын зураг түрүүлж, хамгийн их "LIKE, SHARE" авсан бүтээлээр 5А ангийн сурагч Э.Эгшиглэнгийн зураг тодорлоо. Дунд ангиас Б.Хонгорзул, Э.Анунгоо нарын бүтээл шалгарч, хамгийн их "LIKE SHARE" авсан бүтээлийн эзэнээр 7А ангийн сурагч Г.Энхжин шалгарсан юм.

БАЯРЫН ХУРЛАА ЗОХИОН БАЙГУУЛЖ, ЗАРИМ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛЛАА

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 113 дугаар тусгай ротын бие бүрэлдэхүүн 03 сарын 17-ны өдөр Зэвсэгт хүчний 256 дугаар анги болон Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цэргийн штабын хамт олонтой хамтарч Монгол Улсын баатар Аюушын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлээ. Тус үйл ажиллагааны дараа Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын хурлыг аймгийн хөгжимт драмын театрт зохион байгуулж зарим тэргүүний цэргийн алба хаагчдад төрийн болон салбарын одон медаль, цэргийн цол олголоо. Үүнд, агаарын цэргийн командлагчийн тушаалаар дэд ахлагч цолоор планшетчин П.Амар-Өлзийжаргал, Х.Амаржаргал



нарыг, ахлах ахлагч Б.Цэрэндорж, О.Чимэддаш нарыг аймгийн засаг даргын жуух бичгээр, ахлах ахлагч Д.Мөнхбат,

Ц.Бат-Очир нарыг аймгийн ИТХ-ын жуух бичгээр тус тус шагнаж урамшууллаа.

ХОВДЫН ХОРООНЫ АВАРГУУД ТОДОРЛОО

Зэвсэгт хүчний 123 дугаар анги



"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жил, анги байгуулагдсаны түүхт 99 жилийн ойг угтаж ангийн аварга шалгаруулах марш тактик-тусгай бэлтгэлийн тэмцээнээ зохион байгуулан явууллаа. Ангийн алба хаагчдын бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл, цэргийн мэргэжлийн ур чадварыг сорин өрсөлдсөн тус тэмцээнд ахмад Г.Мөнхболд захирагчтай

байнгын бие бүрэлдэхүүний салаа, дэслэгч Г.Хувьзаяа захирагчтай хугацаат цэргийн алба хаагчдын салаа, ахмад Г.Оюун захирагчтай эмэгтэй тасаг тус тус тэргүүн байр эзэллээ.

Мөн ахлагч нарын эрүүл мэнд, бие бялдарын бэлтгэлжилтийг дээшлүүлэх жил болсонтой холбогдуулан ангийн бялдаржуулах танхимын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж бие бүрэлдэхүүний

биеийн жингийн зохистой харьцааг хангуулах талаар тодорхой ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд жингийн илүүдэлтэй бүрэлдэхүүнд мэдэгдэх хуудсыг хүргүүлж долоо хоног бүрийн "Пүрэв" гарагийг биеийн тамир, спортын өдөр болгож идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамруулж байх юм.

Ахмад Э.ЗОЛЗАЯА

"АМИНААС ҮНЭТЭЙ ЭХ ОРОН" УУЛЗАЛТ БОЛОВ

Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлс, орон нутгийн хөгжлийн асуудлыг хүүхэд залуучуудад таниулан ойлгуулах, төлөвшүүлэх, Ахмад дайчдын гавьяа зүтгэлийг алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор Дорнод аймгийн Цэргийн штаб "Аминаас үнэтэй эх орон" гурван үеийн уулзалт ярилцлага нэвтрүүлгийг бэлтгэн орон нутгийн телевизүүд, Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Цэргийн штабын албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтийн хүртээл болгож байна.

ОЛОН ТӨРЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЦАХИМААР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Өвөрхангай аймаг ЗДТГ-ын Цэргийн штаб

Зэвсэгт хүчний 256 дугаар анги, аймгийн цэргийн штаб хамтран тус ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд захидлын уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 150 гаруй бүтээл ирснээс Зенит артиллерийн батареийн байлдагч М.Чинхусэлийн "Аавдаа бичсэн захидал", дэд түрүүч Б.Золжаргалын "Ээждээ бичсэн захидал", танкийн 2 дугаар ротын байлдагч Б.Лувсан-Очирын "Эх орондоо бичсэн захидал" сэдэвт бүтээлийг шилдгээр шалгаруулан аймгийн Засаг даргын "Өргөмжлөл" мөнгөн шагналаар шагналаа.

Түүнчлэн эх орныхоо өмнө хүлээсэн иргэний үүргээ хүндэтгэлтэйгээр биелүүлж, 1984-1992 оны хооронд 5-6 хүүгээ хугацаат цэргийн алба хаалгаж, Батлан хамгаалах үйлсэд сэтгэл, зүтгэл, хөдөлмөрөө зориулсан Өвөрхангай аймгийн Төгрөг сумын малчин С.Цэдэнсодном, Хужирт сумын малчин Ю.Доржсурмаа, Арвайхээр сумын иргэн Д.Эрдэнэ-Очир нарын шилдэг 3 гэр бүлд хүндэтгэл үзүүлж, аймгийн Засаг дарга, Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагчийн нэрэмжит "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнаж



алдаршууллаа. Мөн "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулан төрийн цэргийн байгууллагууд, нутгийн иргэдийн дунд "Эх орон танаа" цэргийн дуу дуулаачдын аймгийн 6 дахь удаагийн уралдааныг зохион байгууллаа.

Аймгийн Цэргийн штаб, Боловсрол, соёл, урлагийн газар, Хайрхандулаан сумын Соёлын төвтэй хамтран цахимаар 2 үе шаттайгаар зохион байгуулсан тус уралдаанд Богд сумаас оролцогч А.Пүрэвдорж, Зүүнбаян-Улаан сумаас оролцогч Б.Сувд-Эрдэнэ, Хайрхандулаан сумаас оролцогч

А.Даваадорж нар эхний 3 байрыг эзэлж, тусгай байрт Зэвсэгт хүчний 256 ангийн ахлагч Л.Төмөрбаатар шалгарав.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд цэрэг-эх орны сэдвээр зохион байгуулсан "АХА" тэмцээнд "Мэргэд" лаборатори сургуулийн 12Б ангийн сурагч Э.Дэлгэрбаяр, 11А ангийн сурагч Ц.Мөнхбилэгт, Ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн 11Б ангийн сурагч Д.Дэрэм нар эхний 3 байрт шалгарлаа.

Дэд хурандаа Ч.АДЬЯА

ТҮҮХТ ОЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮД АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА

Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд бүхий л төрлийн арга хэмжээг цахим хэлбэрээр орон нутагтаа зохион явуулав. Энэ хүрээнд "Цэргийн дууг хэн сайн дуулах вэ" дууны уралдаан, хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орноо хайрлахын утга учрыг мэдрүүлэхийн тулд Ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчдын дунд "Эх орон юунаас эхлэх вэ" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, иргэд, залуусын дунд "Аавдаа бичсэн захидал" захидлын уралдаан, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 311 ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Би эх орны хүү" шүлгийн уралдааныг тус тус зохион байгуулж шилдгүүдийг шалгарууллаа.

Мөн БНМАУ-ын баатар Дуламдоржийн Самдан, БНМАУ-ын баатар, хурандаа генерал Бутачийн Цог, Монгол Улсын баатар Пунцагийн Шагдарсүрэн болон Төв аймгаас төрөн гарсан генералуудын байгуулсан өнө мөнхийн гавьяа зүтгэлийг ард иргэд, хүүхэд залуучуудад таниулах зорилгоор "Аранзал тугийн намираандор" телевизийн нэвтрүүлгийг бэлтгэж олон түмэнд хүргэлээ. Уг нэвтрүүлэгт зохиолч, яруу найрагч, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан Шагдарсүрэнгийн



Цэрэндоо оролцож Төв аймгаас төрөн гарсан баатруудын түүх, Зэвсэгт хүчинд оруулсан Төв аймгийнхны оролцооны талаар ярилцлаа. Түүнчлэн Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбоотой хамтран бэлтгэл офицерын амьдралын туршлага, сургамжийн тухай "Дурсамжит яриа" цуврал нэвтрүүлэгт ЗДТГ-ын Цэргийн штабын дарга асан

бэлтгэл хурандаа Б.Эрдэнэбат, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Захирагчийн орлогч, дэд хурандаа Н.Лхагвасүрэн, ахлах ахлагч Е.Дашзэвэг нарыг "Энхийн үйлсэд Монгол цэрэг" телевизийн нэвтрүүлэгт оролцож иргэд олон нийтэд Зэвсэгт хүчнийг сурталчиллаа.

Ахмад С.СОЛОНГО



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАЛМБА,
Д.НАПАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сониний редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сониний мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029